



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 09 сарын 07 өдөр

Дугаар А/126

Шивээговь сум

Нээлттэй хаалганы өдөрлөг зохион
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1, 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаал “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Төрийн үйлчилгээг иргэдэд үзүүлэх Нээлттэй хаалганы өдөрлөгийг 2023 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр зохион байгуулсугай.

2.Нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Д.Отгонжаргал
(Засаг даргын Тамгын газрын дарга)

Гишүүд:

С.Отгонбаатар
(1 дүгээр багийн Засаг дарга)
Б.Алтансүх
(Нийгмийн бодлогын мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Н.Амаржаргал
(Мэдээ мэдээлэл, олон нийттэй харилцах ажилтан)
М.Гантуяа
(Хууль, эрх зүй хариуцсан мэргэжилтэн)

3.Нээлттэй хаалганы өдөрлөгийн үйл ажиллагааны удирдамжийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4.Нээлттэй хаалганы өдөрлөгийн үйл ажиллагаанд зарцуулагдах 215,000 (хоёр зуун арван таван мянга) төгрөгийг Засаг даргын нөөц хөрөнгөөс зохих журмын дагуу гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ч.Сугармаа), нягтлан бодогч (Б.Түвшинжаргал) нарт зөвшөөрсүгэй.

5.Сумын Нээлттэй хаалганы өдөрлөгийг чанартай зохион байгуулж, үйл ажиллагааны үр дүнг тайлагнаж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2023 оны 09-р
Сарын 07-ны өдрийн 11/005 тоот
Захирамжийн 1-р хавсралт



**“Нээлттэй хаалга”-ны өдөрлөг
зохион байгуулах ажлын удирдамж**

2023.09.06

Зорилго: Нийгмийн салбарын аж ахуй нэгж, байгууллагуудын үйл ажиллагааг иргэдэд сурталчлан таниулах, салбарын үйлчилгээг иргэдэд нэр дороос хүртэх боломжийг олгох, үйлчилгээний талаар иргэдийн саналыг авахад оршино.

Нээлттэй хаалганы өдөрлөг зохион байгуулах газар: Сумын төв талбайд 2023 оны 09-р сарын 12-ны өдрийн 11:00-17:00 цаг хүртэл

Зохион байгуулагч: Сумын ЗДТГ, Соёлын төв

Хамрах хүрээ: Шивээговь сумын иргэд

Хийгдэх арга хэмжээ:

- ❖ Аж ахуй нэгж, байгууллагын танилцуулга хийх, хэрэгцээт мээдээллээр иргэдийг хангах, холбогдох материал тараах
- ❖ “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үзэсгэлэн худалдаа
- ❖ АХА уралдаан тэмцээн

АХА тэмцээнд оролцоход тавигдах шаардлага: Бүх насны иргэд оролцох боломжтой.

Шагнал, урамшуулал

АХА тэмцээн

- 1 дүгээр байр – Өргөмжлөл, мөнгөн шагнал
- 2 дугаар байр- Өргөмжлөл, мөнгөн шагнал
- 3 дугаар байр – Өргөмжлөл, мөнгөн шагнал



Сумын Засаг даргын 2023 оны 09-р
Сарын 07-ны өдрийн 1/186 тоот
Захирамжийн 2-р хавсралт

**“Нээлттэй хаалга”-ны өдөрлөг зохион байгуулахад
шаардагдах төсөв**

2023.09.06

№	Үйл ажилагаа	Тоо хэмжээ	Нэг бүрийн үнэ /төг/	Нийт үнэ /төг/
1	АХА тэмцээн шагнал	3	20000	60000
2	Баннер	1	100000	100000
3	Баннер /эх бэлтгэл/	1	10000	10000
3	Өргөмжлөл	3	15000	45000
4	Нийт төсөв			215000